

ТӨРИЙН АУДИТ



Үндэсний аудитын газрын харьяа Дорнод
аймгийн Аудитын газрын 2016 оны эхний хагас
жилийн үйл ажиллагааны тайлан

2016.07.08

Гарчиг

Товчилсон үгийн тайлбар.....	2
Удирдлага зохион байгууллалт.....	3
Санхүүгийн тайлангийн аудитын талаар.....	5
Гүйцэтгэлийн аудитын талаар.....	7
Нийцлийн аудитын талаар.....	7
Эрсдэлийн аудитын талаар.....	8
Дотоод ажлын талаар.....	10
Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар.....	11
Дүгнэлт, санал.....	13

Товчилсон үгийн тайлбар


МУ	Монгол Улс
ОХУ	Оросын холбооны улс
ТАТХ	Төрийн аудитын тухай хууль
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
УБ	Улаанбаатар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МНБ	Монголын мэргэшсэн нягтлан бодогч

ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэгдүгээр бүлэг. Удирдлага зохион байгуулалт

Дорнод аймгийн Аудитын газар нь 2016 онд МУ-ын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан ҮАГ-ын 2013-2018 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөнд үндэслэн аймгийн Аудитын газрын 2016-2018 онд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөөг боловсруулан баталсан.

Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 42 ажил, үйлчилгээг 7 багцад хуваан хийхээр төлөвлөж, **“Ес зүй хариуцлагыг сайжруулах”** зорилтын хүрээнд санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын 3 багийн зохион байгуулалтаар дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор-2, ахлах шинжээч, аудитор, шинжээч-4, жолооч гэсэн 11 орон тоотой ажиллалаа.



Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг багц тус бүрээр авч үзвэл:

- ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийх гүйцэтгэл, нийцэл, санхүүгийн аудитын 1,2,3-р багц ажлуудад тусгагдсан 16 аудитаас 10 аудит эхний хагас жилд хийгдэхээр батлагдсаныг бүрэн хийж, мөн төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт нийцлийн аудит хийж нийт 11,4 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс, 36.0 сая төгрөгийн зөрчилд 16 төлбөрийн акт тогтоож, 1,9 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаардлага өгч нийт 20416 хүн/цаг зарцууллаа.
- Өөрсдийн төлөвлөгөөгөөр хийх аудитын 4-р багц ажилд тусгагдсан 3 аудитаас 2 аудитын хугацаа болоогүй, Монгол Улсад гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх нийцлийн аудит гүйцэтгэлийн үе шатандаа явж байна.

- Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний 5-р багцад тусгагдсан төсвийн төсөлд санал өгөх ажлын хугацаа болоогүй байгаа бөгөөд төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд нам эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг ҮАГ-аас ирүүлсэн аргачлалын дагуу тооцон тогтоож хуулийн хугацаанд нь аймгийн ИТХ-д хүргүүлсэн.
- Мэргэжил, арга зүй, шинжилгээний 6-р багцад тусгагдсан 7 ажлаас, 4 ажил бүрэн хийгдэж, мэргэжлийн тасралтгүй сургалт зохион байгуулах ажлын хугацаа болоогүй, 2 ажил хугацаандаа хэрэгжээгүй. Хэрэгжээгүй 2 ажлаас ТАБ-ын хэмжээнд мөрдөгдөж буй бодлого чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлогт тохирсон гарын авлага боловсруулах ажил нь ҮАГ-аас журам заавруудыг шинэчлэн боловсруулж байгаатай холбоотойгоор хойшлогдож, харилцагч байгууллагуудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажил нь Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан хийгдсэн төлөвлөгөөт бус ажлуудаас шалтгаалж хойшлогдсон.
- Бусад ажлын 7-р багцад тусгагдсан 15 ажлаас 4 ажлын хугацаа болоогүй, 11 ажил нь төлөвлөгөөний дагуу хийгдсэн.

Аймгийн Аудитын газар нь эхний хагас жилийн байдлаар төсвөөс 103,8 сая төгрөгийн санхүүжилт авахаас 103,8 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсөвт 32,7 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн аудит


Орон нутагт дахь 206 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулахаас 21 байгууллагад итгэл үзүүлэн, 65 байгууллагыг түүвэрт хамруулан, СТАУС программд 120 байгууллагыг бүрэн оруулж, 119 байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулахад 5992 хүн/цагт 30,5 сая төгрөгийн өртөг зарцуулан ажиллаа.

Үүнд: Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, төвлөрүүлэн захирагчийн 14 сумын нэгтгэсэн тайлан, 74 шууд захирагчийн тайлан, 18 тусгай сангуудын тайлан, 12 орон нутгийн болон төрийн өмчит үйлдвэрийн газруудын тайлан хамрагдсан.

Аудитад хамрагдсан 114 байгууллагуудад зөрчилгүй, Дорнод Их сургууль, Мал аж ахуй Эрдэм шинжилгээний хүрээлэн, Автотээврийн төв, Халхгол сумын ЗДТГ зэрэг 4 байгууллагад хязгаарлалттай, Халхгол сумын Эмийн эргэлтийн санд дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлт өгч ажиллалаа.

Цагаан-Овоо сумын Эмийн эргэлтийн сан нь одоог хүртэл санхүүгийн тайлангаа төсвийн хуульд заасан хугацаанд ирүүлээгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,8 тэрбум төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 4,9 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулан санхүүгийн тайланд нэгтгүүллээ. Илэрсэн зөрчилд 6,5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 1,9 тэрбум төгрөгийн зөрчилд 69 албан шаарлага өгч ажиллалаа.



Нийт зөрчлийг графикаар үзвэл Орлого бүрдүүлэлт 7,6 сая төгрөг, Нягтлан бодох бүртгэл тайлагнал 5488,2 сая төгрөг, хууль тогтоомжийн хэрэгжилт 297,3 сая төгрөг, аривлан хэмнэлт 222,2 сая төгрөг, төсвийн төлөвлөлт 132,9 сая төгрөг, дотоод хяналт 435,9 сая төгрөг, худалдан авалт 19,8 сая төгрөг, бусад 2324,2 сая төгрөгийг эзлэж байна.

Орон нутгийн өмчийн алба нь Зүүн бүсийн зөвлөлийн элэгдлээ бүрэн нөхөөгүй үндсэн хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар элэгдлээ нөхсөнөөр хэлэлцүүлж “Хөрөнгө ашиглалтаас хасч, устгах тухай” тогтоол гаргуулан орон нутгийн өмчөөс хассан байна. Иймд Орон нутгийн өмчийн албаны дарга Б.Батдоржид хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

Мөн Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа ирүүлээгүй 21 байгууллагын удирдлага, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллаагүй, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзах дүгнэлт авсан зэрэг Баяндун сумын Засаг дарга Б. Батжав, Халхгол сумын ЗДТГ-ын дарга Б.Баярмагнай, Халхгол сумын Сум дундын эмнэлгийн дарга, Их эмч З.Байгалмаа, Чойбалсан хөгжил ОНӨҮГ-ын дарга Ц.Сүхбаатар нарт Төрийн Аудитын тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцуулах болон ажлаас халах хүртэлх саналыг эрх бүхий албан тушаалтнуудад тус тус хүргүүлээд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн хуульд заасан хугацаанд нэгтгэсэн тайлангаа ирүүлээгүй, хөрөнгө оруулалтаар бий болсон 92,1 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 34,5 сая төгрөгийн авлаг, өр төлбөрийг бүртгэл тайланд тусгасан, аймгийн ИТХ нь 4, АЗДТГ нь 11-ээр орон тоог илүү батлуулан ажиллаж үр ашиггүй зардал гаргасан, аудитаар санхүүгийн тайлангаа батлаажуулаагүй Цагаан-Овоо сумын Эмийн эргэлтийн сангийн тайланг нэгтгэн ирүүлсэн зэрэгт хариуцлага тооцуулах саналыг шат шатны түвшинд шийдвэрлэж өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлэн ажилласан.

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудит

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийсэн төлөвлөгөөт 3 аудитад 24 байгууллагыг хамруулан, 27,4 сая төгрөгийн өртөг, 5400 хүн/цаг зарцуулж, нийт 2519,6 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 19,0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон үр өгөөжөөр

бүртгэж, 960,2 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага өгч, 34 зөвлөмж өгч ажиллалаа.

Үүнд:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудит хийж 12 сумын хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь үзэж шалгалаа.



Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 1149.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 60.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой 1028.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 19.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 899.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага өгч нийт 20 зөвлөмж өглөө.



Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд болон аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн, аймгийн ерөнхий нягтлан бодогч нарыг оролцуулан хийж, 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.

2. Дорнод аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө гүйцэтгэлд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудит хийсэн.



Аудитаар 331.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 6 зөвлөмж өгсөн.

Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд, Дорнод аймгийн Засаг дарга, аймгийн ерөнхий нягтлан бодогч нарыг оролцуулан хийж, 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.

3. Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, үр дүнд ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудит хийсэн.



Аудитаар 9.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 0,4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 9.5 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.



Аудитын явц дахь нөөцийн бараа материалын биет тооллого

Аудитын хэлэлцүүлгийг тэргүүлэх аудитор, гүйцэтгэлийн аудитын багийн гишүүд, Дорнод аймаг дахь Улсын нөөцийн салбарын даргыг оролцуулан хийж, 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдөр тайланг баталгаажуулан ҮАГ-т хүргүүлсэн.


Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудит

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар хийсэн төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 1 аудитад 233 байгууллага, 75 нэр дэвшигчийг хамруулан, 45,9 сая төгрөгийн өртөг, 9024 хүн/цаг зарцуулж, нийт 49,9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 10,5 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 4,3 сая төгрөгийн үр өгөөж бүртгэж, 39,4 сая төгрөгийн зөрчилд 44 албан шаардлага өгч, 11 зөвлөмж өгч ажиллалаа.

Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалтад ҮАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу нийцлийн аудит хийж 12 сумын хөрөнгө оруулалтын ажлыг газар дээр нь үзэж шалгалаа.

Зөрчлийн нэгтгэл



Аудитаар 49.9 сая сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,5 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 39,4 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 10 зөвлөмж өгсөн.



Хөрөнгө оруулалтуудын болон Шилэн дансны аудитаар сумдад

ОНХС-ын тухай хууль, журмыг зөрчин урсгал зардалд Хэрлэн сумд 6,2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг хүлээн зөвшөөрөлгүй ЯАГ-ын Чанарын албанд гомдол гаргасанд, Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын дагуу тайлбар хүргүүлсэн.

Өмнөх оны аудитаар тавигдсан төлбөрийн актыг барагдуулаагүй Цагаан-Овоо сумын Засаг дарга Ө.Амарсайханыг ТАТХ-ын 28.2-т заасны дагуу ажлаас халах саналыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

Аудитын үр дүнгийн талаарх хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд тэргүүлэх аудитор, нийцлийн аудитын багийн гишүүд болон аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтэн, Худалдан авах ажиллагааны албаны дарга, аймгийн ерөнхий нягтлан бодогч нарыг оролцуулан хийж, 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр тайланг баталгаажуулан ЯАГ-т хүргүүлсэн.

2. Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ЯАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу нийцлийн аудит хийсэн.

Аудитаар нийт 211 байгууллагын мэдээллийг шалган, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 12 сумд очин газар дээр нь үзэж хуулийн заалтуудын дагуу мэдээллээ бүрэн байршуулаагүй 4 байгууллагад хууль мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

3. Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор орон нутгийн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт төлөвлөгөөт бус нийцлийн аудитыг хийсэн.

Аудитаар 2016 оны орон нутгийн сонгуульд оролцох 6 улс төрийн нам, 75 бие даагч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө ирүүлснээс 30 бие даан нэр дэвшигч сонгуульд оролцохгүй болсон шалтгаанаар хөтөлбөрөө буцаан авсан.

Аудитын явцад мөрийн хөтөлбөр дэх хуулийн шаардлагад нийцэхгүй байгаа заалтуудыг залруулах тухай 32 албан шаардлагыг нам, нэр дэвшигчдэд хүргүүлж, 2016.04.20-2016.05.10-ны өдрийн хугацаанд 6 улс төрийн нам, 45 нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлтийг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсэн. Үүнээс МҮАН-ын мөрийн хөтөлбөрт нийцээгүй дүнэлт өгч, бусад нам, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт нийцсэн дүгнэлтийг өгсөн.

Тавдугаар бүлэг. Иргэдийн хурлын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудит

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд ИТХ болон өөрийн санаачлагаар 3 аудит хийхээр тусгагдсанаас 2 аудит нь 3 дугаар улиралд эхлэх бөгөөд Монгол Улсад гадаадаас ажиллах хүч авч ажиллуулахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх нийцлийн аудит гүйцэтгэлийн үе шатандаа явж байна.

Зургадугаар бүлэг. Дотоод ажил

Сургалт

Эхний хагас жилийн байдлаар ҮАГ-аас зохион байгуулсан 4 сургалтад нийт 18 хүн хамрагдсан. Үүнд:

1. СУГ-ын менежер, шинжээчдээс бүрдсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй сургалтын баг ирж АДБОУС, арга зүйн талаар сургалт зохион байгуулж тэргүүлэх аудитор, аудитын менежер болон ахлах, аудитор, шинжээчид бүрэн хамрагдсан.

2. Сонгуулийн зардлын хэмжээ тогтоохтой холбоотой арга зүйн онлайн сургалтыг СУГ-аас зохион байгуулж тэргүүлэх аудитор, аудитын менежер хамрагдсан.

3. САГ-аас ҮАГ-т зохион байгуулсан СТАУС-ыг хөгжүүлэх, ГА-ын үе шатны ажлыг цахимжуулахтай холбоотой хэлэлцүүлэгт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр очиж оролцсон.

Бусад байгууллагаас зохион байгуулсан 6 сургалтад нийт 7 хүн оролцсоноос Үндэсний архивын газраас УБ хотод зохион байгуулсан албан хэрэг хөтлөлтийн сургалтад шинжээч, бичиг хэргийн ажилтан Я.Зориг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа: иргэдийн оролцоо, хяналт, шилэн дансны хэрэгжилтийн сургалтад тэргүүлэх аудитор Б.Болортуул, нягтлан бодогч Д.Нармандах, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын сургалтанд нягтлан бодогч Д.Нармандах, ММНБИ-ээс зохион байгуулсан МНБ-ийн хугацаагүй эрх олгох сургалтанд тэргүүлэх аудитор Б.Болортуул, аудитын менежер В.Цэнгэлмаа, ахлах аудитор Д.Нармандах нар хамрагдаж МНБ-ын хугацаагүй эрхээ авсан.

Хамтын ажиллагаа

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд орон нутаг дахь ТАБ-уудтай туршлага солилцох, харилцагч байгууллагуудтай уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, иргэд, олон нийттэй харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлууд тусгагдсанаас эхний хагас жилийн байдлаар биелэлт 75 хувьтай байна.



Туршлага солилцох цугларалт
/Дорноговь, Дорнод, Говь-Алтай/



Авлигын эсрэг хамтдаа /ИТХ, УБСХэлтэс, ХААА/

Иргэд олон нийттэй харилцах, мэдээлэл солилцох зорилгоор 2015 оноос нээн ажиллуулж буй Facebook хуудсанд 2016 оны эхний хагас жилийн байдлаар 25 мэдээлэл байршуулж, иргэд олон нийтээс 9153 хандалт авсан байна. Мөн audit.mn цахим хуудсанд хийсэн аудитуудтай холбоотой мэдээлэл, Шилэн дансны цахим хуудсанд төсөв, санхүүтэй холбоотой мэдээллүүдийг тогтмол байршуулж ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудит, улс орон нутгийн болон ОНХС-гийн хөрөнгө оруулалтын аудитуудын талаар телевиз, байгууллагуудад 4 удаа мэдээлэл хийлээ.



Төлөвлөгөөнд тусгагдаагүй ч аймгийн хэмжээнд зохион байгуулсан хамт олноороо мод тарих аянд хамрагдаж өмнөх жилийн тарьсан модоо 50-иар нэмэгдүүллээ. Хувийн хэвшлийн Нью эндорфин эмнэлэгтэй хамтын ажиллагаа эхлүүлж ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд үнэ төлбөргүйгээр бүрэн хамрууллаа.

Өргөдөл гомдол шийдвэрлэлт

Эхний хагас жилийн байдлаар иргэдээс төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил шалгуулах тухай 6, тайлан, мэдээлэл авах тухай 2 хүсэлт ирүүлснээс 6 хүсэлтийг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүлж, 2 хүсэлтийн дагуу асуудлыг судалж байгаа бөгөөд хариу хүргүүлэх хугацаа болоогүй байна.

Шинэ санаачлага

Ажиллагсадын санаачлагаар хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хамт олныг идэвхжүүлэх зорилгоор 7 хоног бүр волейболын спортоор хичээллэх цаг гарган тогтмолжууллаа. Мөн хамтын сангийн хуримтлалыг бий болгосон нь ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зохих хэмжээний дэмжлэг болж байна.

Долдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

2016 оны 2 дугаар улирлын тайланг Санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Татвар болон нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох журам зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузл сууриар илэрхийлэн гаргасан.

Тайлант хугацаанд 103,9 сая төгрөгийн батлагдсан төсөвтэйгээс 103,8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үйл ажиллагааны тайланг санхүүгийн CTS программар гаргаж татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангуудыг бүрэн үзүүлэлтээр нь гарган холбогдох газруудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын тайлан мэдээг сар бүр гаргаж УАГ-т хүргүүлж ажилласан.

Мөн 2016 оны төсвийн хуваарийг хийхдээ аудит хийх төлөвлөгөө хуваарийн дагуу амралтын хугацаа, цалинг тооцоололгүй батлагдсан төсвийг 12 сард нь тэнцүү хуваариалж ирүүлснээс үүдэн 8,8 сая төгрөгийн өр төлбөр үүсээд байна.

Наймдугаар бүлэг. Дүгнэлт санал

Дорнод аймгийн Аудитын газар нь 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 42 ажлаас эхний хагас жилд 27 ажлыг хийхээс 25 ажлыг бүрэн хийж, Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор төлөвлөгөөт бус сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох, нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах ажлуудаас шалтгаалж 2 ажлын хугацаа хойшлогдсон.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистикийн мэдээг боловсруулж, тайлагнах журмын дагуу СМ1-СМ8 гэсэн 8 төрлийн мэдээ гаргахаас СМ6 буюу төсвийн төсөлд өгөх санал эхний хагас жилийн байдлаар гараагүй, СМ7 буюу дотоод аудитын мэдээ орон нутагт бөглөгдөхгүй тул бусад 6 мэдээг гарган хүргүүлээ.

Байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган явуулахад тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын 50-60 хувь нь элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглагдах боломжгүй эвдэрсэн, 3 аудитор шинжээч нарын компьютер бүрэн ажиллахгүй байна.

Иймд Санхүүгийн тайлангийн аудит нь СТАУС програмд шилжсэнээр СТАУС програмыг ажиллуулахад шаардагдах үзүүлэлт бүхий компьютер, тоног төхөөрөмжийн шаардлагыг үндэслэн судалгааг доорх хүснэгтээр гарган хүргүүлж байна.

2016 оны эхний хагас жилийн ажлын тайлан

№	хөрөнгийн нэр	Марк	нэг бүрийн хүн	тоо хэмжээ	2017 оны дүн
А. Биет хөрөнгө					
1	Суурин компьютер	Процессор: Dell Optiplex9020MT Core i7/4770 3,4ghz, RAM8Gb8 HDD 1Tb, Card1Gb	1 949 000,00	8	15 592 000,00
	Суурин компьютер	Дэлгэц: DellS2240T 21,5 inch, Multi-Touch LED	699 000,00	1	699 000,00
	Суурин компьютер	DellS2240L 21,5 inch LED	399 000,00	7	2 793 000,00
2	Зөөврийн компьютер	Процессор: Dell Optiplex9020MT, RAM8Gb8 HDD 1Tb, Card1Gb	3 499 000,00	2	6 998 000,00
3	Канон, принтер /олон үйлдэлтэй/	DellS2240T 21,5 inch, Multi-Touch LED	450 000,00	3	1 350 000,00
	Канон, принтер /олон үйлдэлтэй/	Dell Optiplex9020MT Core i7/4770 3,4ghz, RAM8Gb8 HDD 1Tb, Card1Gb	3 305 900,00	1	3 305 900,00
4	Камер дагалдах хэрэгслийн хамт	Dell	3 999 900,00	1	3 999 900,00
5	Микрофон	-	60 000,00	10	600 000,00
6	Чихэвч	-	60 000,00	10	600 000,00
дүн					35 937 800,00
Б.Биет бус хөрөнгө					
	Архивын програм		2 000 000,00	1	2 000 000,00
дүн					2 000 000,00
нийт дүн					37 937 800,00

Мөн цааснаас татгалзан цахим хэлбэрт шилжиж байгаатай холбогдуулан архивын програмтай болох шаардлагатай байна. Түүнчлэн манай байгууллагын хувьд ОХУ-ын хуучин консулын орон сууцны 2 өрөө байранд үйл ажиллагаагаа явуулдаг учраас бичиг баримт, тайлан мэдээгээ хадгалах өрөө тасалгаа байдаггүй. Иймээс яаралтай архивын ажлаа цахимжуулж програмтай болгох шаардлагатай байна. Одоогийн байдлаар компьютер дээрээ архивлаад явж байгаа хэдий ч компьютерүүдийн маань хүчин чадал муу учраас хүнд байна.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**